

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий  
газрын даргын 2024 оны 10 сарын 21-ны өдрийн  
11:19:08 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ТЭГШ ХҮРТЭЭМЖ-2024”  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ**

**Нэг. Үндэслэл**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ийн конвенцын 8 дугаар зүйл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг тус тус зүйл, Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн нэг гишүүн байж, бусдын адил сурч, үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн нэг гишүүн байж, бусдын адил сурч, боловсорч, хөдөлмөр эрхлэх, эрүүл амьдрах бүрэн эрхтэйг нийгэмд ойлгуулж, тэдний нийгэмд эзлэх байр суурийг нийгмийн бүхий л давхаргад бий болгох, хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, иргэдэд хүрч байгаа бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг судалгаа, шинжилгээнд тулгуурлан үзүүлэх шаардлагатай байна.

Энэхүү хурал нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бүхий л салбарт судалгаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн оюутан, эрдэмтэн, багш, судлаач, шинжээчдийн оролцоо, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, мэдээлэл солилцох, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, тэдний бүтээлийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилготой юм.

**Хоёр. Сэдэв**

Хөгжлийн бэрхшээл судлалд шинэ санаа, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралд тэгш хүртээмжтэй оролцох нөхцөл боломж, техник технологи туршин нэвтрүүлэх чиглэлээр доорх сэдвээр нээлттэй оролцоно уу.

- Эрүүл мэнд
- Боловсрол
- Хөдөлмөр эрхлэлт
- Нийгмийн хамгаалал
- Дэд бүтэц
- Хууль, эрх зүй

**Гурав. Ерөнхий зүйл**

- 3.1 “Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж-2024” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг үндэсний хэмжээнд нээлттэй зохион байгуулна.
- 3.2 4 шагналт байр шалгаруулна. Үүнд:

I байр – 2.000.000 төгрөг, өргөмжлөл

II байр – 1.500.000 төгрөг, өргөмжлөл

III байр – 1.000.000 төгрөг, өргөмжлөл

Тусгай байр- 500 000 төгрөг, өргөмжлөл

#### **Дөрөв. Зохион байгуулалт**

4.1 Хэзээ: 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 09:00 цаг

4.2 Хамрах хүрээ: Хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, их дээд сургуулийн оюутан /бакалавр, магистр, докторант/, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, багш, судлаач, шинжээчид оролцно.

4.3 Ерөнхий зохион байгуулагч: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

4.4 Хаана: ХБХХЕГ-ын 8 давхарт

#### **Тав. Бүртгэл**

5.1 Эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээж авах хугацаа: 2024.10.23-ны өдрийн 09:00 цагаас 2024.11.18-ны 12:00 цаг хүртэл [research@gadpwd.gov.mn](mailto:research@gadpwd.gov.mn) хаягаар хүлээн авна.

#### **Зургаа. Тавигдах шаардлага**

6.1 Эрдэм шинжилгээний өгүүлэл нь дараах шаардлагыг хангасан байвал зохино:

- Хэмжээ**

Өгүүлэл нь МОНГОЛ хэлээр, Microsoft Word программ дээр бичигдсэн байх ба цаасны хэмжээ A4, дээд захаас 25 мм, доод захаас 25 мм, баруун захаас 20 мм, зүүн захаас 30 мм, Arial фонд, үсгийн хэмжээ 12, мөр хоорондын зай 1.5 байна. Өгүүллийг бичихдээ header, footer, footnote командыг ашиглахгүй байна. Нийтээр хэрэглэж заншаагүй товчилсон үгийг өгүүлэлд хэрэглэхгүй байвал зохино.

- Эрдэм шинжилгээний өгүүлэл (ЭШӨ) нь дараах бүтэцтэй байна.

- Өгүүллийн нэр – Arial фондоор, 14pt, Bold, ТОМ ҮСГЭЭР, мөр

голлоно.

- Зохиогчийн нэр, хаяг - Arial фондоор, 12pt, мөр голлоно. зохиогчдын нэрийн баруун дээд өнцөгт 1,2 гэх мэтээр тэмдэглэн нэрсийн доор зохиогчийн албан газрын нэр байна.

- 3) Хураангуй - Arial фондоор 15 мөр 200 үгэнд багтаан, мөрний эхнээс эхлэх ба мөр хоорондын зайд 1sp бичнэ.
- 4) Түлхүүр үг – Өгүүллийн санааг гаргахуйц ганц тоогоор 4-5 түлхүүр үг хэрэглэж бичигдэнэ. Өгүүллийн нэрэнд орсон үг түлхүүр үгэнд орохгүй. Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 5) Удиртгал болон оршил хэсэг- Энэхүү хэсэгт судалгааны мөн чанар, судлагдсан байдал, гол онцлогуудыг бичнэ. Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 6) Судалгааны зорилго, зорилт, шинэлэг байдал, ач холбогдол, Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 7) Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй – /Судалгааны объект, ажлын хэмжээ, хэрэглэсэн арга зүйн нэр, ашигласан багаж, эм урвалжийн нэр, статистик боловсруулалт ямар аргаар хийсэн гэх мэт/ Arial фондоор, 12pt, зүүн, талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 8) Судалгааны үр дүн, шүүн хэлэлцэхүй – /Судалгаанаас гарсан үр дүнг бусад судлаачдынхтай харьцуулан үнэлж дүгнэж тодорхой бичих/ Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 9) Хүснэгт болон зураг нь өгүүлэлд орсон дарааллаараа дугаарлагдана. Хүснэгт болон зургийн гарчиг нь Arial фондоор, 12pt, italic хэлбэрээр мөр голлон (хүснэгт 1. Зураг 1... гэх мэт) бичигдэнэ. Бүх математик бичиглэлүүд MS Equition, MathType, La Tex программаар бичигдэх бөгөөд ердийн математик бичиглэл 12 pt өндөртэй байна. Томъёо нь дээд, доод талаасаа 12 pt зйтэй байх ба мөр голлон бичигдэнэ. Томъёоны дугаарыг тухайн мөрний төгсгөлд бага (1) хаалтанд бичнэ.
- 10) Зургийг JPG форматаар, диаграммыг Microsoft Excel програм дээр үйлдэнэ. Фото зураг, зураг, хүснэгт нь зөвхөн хар, цагаан өнгөтэй байна. Scanner ашиглаж оруулсан бүдүүвч зураг болон фото зураг нь 300-400 dpi-аас багагүй нягтралшилтайгаар зургийн \*.JPEG өргөтгөлтэйгээр буулгагдаж текстэн дотор мөр голлон байрласан байна. Зураг дээрх үсэг, тооны өндөр нь ерөнхий текстийн үсэгний өндөртэй тэнцүү байна.
- 11) Дүгнэлт – /Үр дүнд тулгуурласан товч тодорхой байх/ Arial фондоор, 12pt, мөрүүд нь баруун зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.

12) Талархал - /Уг судалгааг явуулахад тусалсан хамт олон, хүмүүсээ бичих/

13) Ашигласан хэвлэл- Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэх. Өгүүллийн төгсгөлд ишлэл татсан ном, сэтгүүл, зохиолын нэрс, вэб хаягийг бичих бөгөөд өгүүлэлд иш татсан дарааллаар дугаарлана. Нэрсийг Arial фондоор, 12pt үсгийн өндөртэйгээр дараах хэлбэрээр бичнэ. Хэрэв 3-аас дээш хүний нэр орсон хамтын бүтээлээс ишлэл татсан бол эхний 3 хүний нэрсийг бичнэ. Ном зүйн зүүлтийг [...] хаалтанд хийнэ. Жишээ нь: [1].

*Жич: Эмхтгэлд орох материал нь шаардлага хангаагүй өгүүллийг буцаах, зохих хэмжээнд засварлаж болох талтай. Өгүүллийг шаардлагын дагуу бичиж, агуулга, найруулга, үг үсгийн алдаанд анхаарч хянуур нямбай хандахыг хүсье!*

#### **Долоо. Шалгаруулалт**

7.1 Энэхүү эрдэм шинжилгээний хурал нь 2 үе шатаар явагдана.

7.2 Нэгдүгээр үе шатанд ирүүлсэн нийт илтгэлүүдээс 8 илтгэлийг сонгон шалгаруулж, эрдэм шинжилгээний хурал дээр хэлэлцүүлнэ. /Сонгон шалгаруулах хугацаа 2024.11.18-2024.11.25/

7.3 Хоёр дугаар үе шат хэлэлцүүлсэн 8 илтгэлээс шилдэг 4 судалгааны ажлыг шалгаруулж шагналт байр эзлүүлнэ.

7.4 Шагналт 4 байрыг шалгаруулахад дараах үзүүлэлтүүдийг тавина:

- Шинэлэг санаа дэвшүүлсэн байдал
- Практик ач холбогдол
- Асуудал дэвшүүлж, зорилгодоо хүрсэн байдал
- Судалгааны арга аргачлал
- Илтгэх ур чадвар

#### **Найм. Үр дүн**

Энэхүү хурал нь Хөгжлийн бэрхшээлийн салбарын судалгаа, шинжилгээний ажлын бүтээлийг баяжуулах, шинэлэг санааг дэвшүүлсэн, оновчтой гарц шийдлийг олсон, цаашид тулгамдаж буй асуудал, бодлого үйл ажиллагааг сайжруулсан үр дүн гарсан байна.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**